



Эрүүл мэндийн  
хөгжлийн төв

2018.01.07

# **ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ**

**2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР**

**Улаанбаатар хот**

Энэхүү товхимолын дэлгэрэнгүй мэдээллийг  
www.hdc.gov.mn цахим хуудаснаас татаж харна уу!

**Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд**  
**/2017, 2018 оны жилийн эцсийн байдлаар/**

Эрүүл мэндийн хөгжлийн төв  
Эрүүл мэндийн мэдээллийн албанаас эрхлэн гаргав.

Шуудангийн хаяг: 14210 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Энхтайвны  
гудамж, 13в байр

E-mail: admin@hdc.gov.mn, www.hdc.gov.mn

Факс: 976-11-320633

Утас: 7011-1485  
7012-8801

№	Үзүүлэлт	Нэгж	2017 он	2018 он	Өсөлт бууралт
1	Төрсөн эх	Бодит тоо	73884	77058	3174
2	Амьд төрсөн хүүхэд	Бодит тоо	74328	77528	3200
3	Амьгүй төрсөн хүүхэд	Бодит тоо	451	438	-13
		1000 нийт төрөлтөд	6.0	5.6	-0.4
4	Эхийн эндэгдэл	Бодит тоо	20	21	1
		100 000 амьд төрөлтөд	26.9	27.1	0.2
5	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /0-4 нас 364 хоног/	Бодит тоо	1244	1310	66
		1000 амьд төрөлтөд	16.7	16.9	0.2
6	Үүнээс: “Нялхсын эндэгдэл /0-364 хоног/”	Бодит тоо	1009	1037	28
		1000 амьд төрөлтөд	13.6	13.4	-0.2
	Үүнээс: “Нярайн эндэгдэл /0-28 хоног/”	Бодит тоо	647	672	25
		1000 амьд төрөлтөд	8.7	8.7	0.0
		Нялхсын эндэгдэлд эзлэх хувь	64.1	64.8	0.7
	Үүнээс: “Нярайн эрт үеийн эндэгдэл /0-6 хоног/”	Бодит тоо	475	486	11
		“Нярайн эндэгдэлд эзлэх хувь”	73.4	72.3	-1.1
		Бодит тоо	172	186	14
Үүнээс: “Нярайн хожуу үеийн эндэгдэл /7-28 хоног/”	Бодит тоо	172	186	14	
	“Нярайн эндэгдэлд эзлэх хувь”	26.6	27.7	1.1	
7	Перинаталь эндэгдэл	Бодит тоо	926	924	-2
		1000 нийт төрөлтөд	12.4	11.9	-0.5
8	Нийт нас баралт	Бодит тоо	15812	17331	1519
9	Эмнэлэгт нас баралт	Бодит тоо	4292	4721	429
		Хувь	27.1	27.2	0.1
10	Хоног болоогүй нас баралт	Бодит тоо	967	1047	80
		Хувь	22.5	22.2	-0.3
11	Жирэмсний эрт хяналт	Хувь	86.8	88.1	1.3
12	Эмчлэгдсэн өвчтөн	Бодит тоо	853838	902439	48601
13	Ор хоног	Бодит тоо	6142569	6438504	295935

## 1. Эх, хүүхдийн эрүүл мэнд

### 1.1. Төрөлт


Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 77 058 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 3174 төрөлтөөр буюу 4.3 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт Өмнөговь /239/, Орхон /165/, Ховд /153/, Дархан-Уул /148/, Хөвсгөл /113/, Завхан /110/, Баян-Өлгий /69/, Баянхонгор /69/, Говь-Алтай /61/, Говьсүмбэр /55/, Дорноговь /47/, Дорнод /26/, Дундговь /26/, Сүхбаатар /25/, Хэнтий /14/ аймгуудад болон Улаанбаатар хотод /2258/ тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна.

Төрсөн эхчүүдийн 58 669 нь буюу 76.1 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан байна. Нийт төрөлтийн 0.4 хувийг гэрийн төрөлт эзэлж байгаа ба энэ үзүүлэлт Говь-Алтай /0.8/, Дархан-Уул /0.6/, Ховд /0.6/, Хөвсгөл /0.5/, Увс /0.5/ аймгуудад улсын дунджаас өндөр байна. Говьсүмбэр аймагт гэрийн төрөлт бүртгэгдээгүй байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүд 25.8 хувийг эзэлж байгаа ба 32.7 хувь нь төрөлтийн хүндрэлтэй, 67.3 хувь нь хүндрэлгүй төрсөн байна.

**Нийт төрөлтийг эмнэлгийн төрлөөр харуулбал:**

Зураг 1.

**Төрсөн эх, эмнэлгийн төрлөөр /2018 оны жилийн эцсийн байдлаар/**




### 1.2. Хүүхдийн эрүүл мэнд

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 77 528 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 3200 хүүхдээр буюу 4.3 хувиар өсчээ. Амьд төрсөн хүүхдийн 39 787 буюу 51.3 хувь нь хүү, 37 741 буюу 48.7 хувь нь охин байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 105 хүү ногдож байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 3421 нярай буюу 4.4 хувь нь 2500 гр-аас доош жинтэй, 533 тохиолдол буюу 0.7 хувь нь төрөлхийн гажигтай төрсөн байна. Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 96.4 байна. Дутуу төрөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 66.7 байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 5.6 байна.

Зураг 2.


**Амьд төрсөн хүүхдийн тоо /2009-2018 оны 12 дугаар сард/**



**Хүснэгт 1. Төрөлт, нас баралтын үзүүлэлтүүд, бүсээр /2018 оны жилийн эцсийн байдлаар/**

Аймаг, нийслэл	Төрсөн эхийн тоо	Төрөлтийн түвшин	Нас барсан хүний тоо	Нас баралтын түвшин
<b>Бүгд</b>	<b>77058</b>	<b>24.9</b>	<b>17331</b>	<b>5.6</b>
<b>Баруун бүс</b>	<b>9866</b>	<b>24.8</b>	<b>2054</b>	<b>5.2</b>
Баян-Өлгий	2913	29.0	502	5.0
Говь-Алтай	1277	22.4	311	5.4
Завхан	1431	20.0	369	5.2
Увс	1896	23.1	457	5.6
Ховд	2349	27.2	415	4.8
<b>Хангайн бүс</b>	<b>12596</b>	<b>21.4</b>	<b>3320</b>	<b>5.6</b>
Архангай	1737	18.4	516	5.5
Баянхонгор	2066	23.9	505	5.9
Булган	778	12.6	326	5.3
Орхон	2731	26.8	520	5.1
Өвөрхангай	2404	20.9	660	5.7
Хөвсгөл	2880	22.0	793	6.1
<b>Төвийн бүс</b>	<b>9519</b>	<b>19.1</b>	<b>2624</b>	<b>5.3</b>
Говьсүмбэр	471	27.4	64	3.7
Дархан-Уул	2397	23.8	572	5.7
Дорноговь	1365	20.3	402	6.0
Дундговь	904	19.7	264	5.7
Өмнөговь	1536	23.8	323	5.0
Сэлэнгэ	1705	15.8	529	4.9
Төв	1141	12.2	470	5.0
<b>Зүүн бүс</b>	<b>4704</b>	<b>22.0</b>	<b>1153</b>	<b>5.4</b>
Дорнод	1948	24.8	436	5.5
Сүхбаатар	1300	21.4	356	5.9
Хэнтий	1456	19.5	361	4.8
<b>Улаанбаатар</b>				
Улаанбаатар	40373	28.9	8180	5.8

**Зураг 3. 5 хүртэлх насны хүүхдийн жингийн мэдээ, хувиар /2018 оны жилийн эцсийн байдлаар/**



2018 оны жилийн эцсийн байдлаар тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад 2 311 682 хүүхэд хамрагдсанаас 0.26 хувь нь туранхай, 0.20 хувь нь тураалтай, 0.32 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна.

**1.3. Эхийн эндэгдэл**


Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар эхийн эндэгдлийн 21 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 27.1 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1 тохиолдлоор буюу 100 000 амьд төрөлтөд 0.2-оор өссөн байна. Эхийн эндэгдэл Хөвсгөл, Сэлэнгэ аймаг, ЭХЭМҮТ, ХСҮТ, Амгалан, Өргөө амаржих газарт тус тус 1 тохиолдол, Архангай, Дархан-Уул, Шүүх эмнэлэг, УГТЭ-т 2 тохиолдол, Ховд аймагт 3 тохиолдол, УНТЭ-т 4 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Шалтгаанаар нь авч үзвэл жирэмсэн үеийн хүндрэлээр 3, төрөх үеийн хүндрэлээр 3, төрсний дараах үеийн хүндрэлээр 1, 14 тохиолдол нь эрхтэн тогтолцооны эмгэгээр тус тус эндсэн байна.

**1.4. Нялхсын эндэгдэл**

Улсын хэмжээнд нялхсын эндэгдлийн 1037 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 13.4 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28 тохиолдлоор өссөн хэдий ч 1000 амьд төрөлтөд 0.2-оор буурсан үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдлийн 64.8 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа ба 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 8.7 байна. Нярайн эндэгдлийн нийт 672 тохиолдлын 486 буюу 72.3 хувь нь эрт үеийн эндэгдэл, 186 буюу 27.7 хувийг хожуу үеийн эндэгдэл тус тус эзэлж байна. Нялхсын эндэгдлийн 58.1 хувь нь эрэгтэй, 41.9 хувь нь эмэгтэй хүүхэд байна.


1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл Архангай /19.6/, Төв /18.3/, Хөвсгөл /18.0/, Баян-Өлгий /17.8/, Булган /16.6/, Говь-Алтай /16.3/, Өвөрхангай /15.0/, Ховд /14.9/, Өмнөговь /14.8/, Увс /14.1/ аймгуудад болон Улаанбаатарт /13.6/ улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна.

**Зураг 4. Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд /2018 оны жилийн эцсийн байдлаар/**



Шалтгаанаар авч үзвэл: Перинаталь үед үүссэн эмгэг 55.4 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 10.4 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 16.5 хувийг тус тус эзэлж байна.

**Зураг 5. Перинаталь эндэгдэл, 1000 нийт төрөлтөд /2018 оны жилийн эцсийн байдлаар/**



### 1.5. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл


Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 1310 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 16.9 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 66 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 757 тохиолдол буюу 57.8 хувь нь эрэгтэй, 553 тохиолдол буюу 42.2 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Нийт тохиолдлын 27.5 хувь нь гэртээ, 72.5 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс хоног болоогүй нас баралт 26.6 хувийг эзэлж байна.

Шалтгаанаар авч үзвэл: Нийт эндэгдлийн 86.5 хувь нь өвчнөөр, 13.5 хувь нь осол гэмтлийн улмаас эндсэн байна. Перинаталь үед үүссэн эмгэг 43.8 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 12.1 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 14.6 хувь, 13.5 хувийг осол гэмтлийн шалтгаант эндэгдэл эзэлж байна.

1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Төв /26.2/, Архангай /25.3/, Баян-Өлгий /25.0/, Хөвсгөл /23.6/, Булган /22.9/, Завхан /20.3/, Увс /19.9/, Говь-Алтай /19.4/, Өвөрхангай /19.1/, Ховд /19.1/, Баянхонгор /18.8/ аймгуудад улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна.

**Зураг 6. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд /2018 оны жилийн эцсийн байдлаар/**




## 2. Амбулатор, стационарын тусламж үйлчилгээ

2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 17 452 750 үзлэг хийгдсэнээс 30.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 49.2 хувийг өвчний учир амбулаторт, 8.9 хувийг идэвхитэй үзлэг, 11.4 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өвчний учир амбулаторын үзлэг 2.2 хувиар өссөн байна.

Эмнэлгийн шатлалаар нь авч үзвэл нийт үзлэгийн 32.2 хувийг өрхийн эмчийн, 13.0 хувийг баг, сумын, их, бага эмчийн, 27.7 хувийг аймаг дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмчийн, 27.1 хувийг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд болон бусад эмнэлгийн эмчийн үзлэг эзэлж байна.

**Зураг 7. Амбулаторын үзлэгийн төрөл, хувиар /2017, 2018 оны жилийн эцсийн байдлаар/**



### 2.1. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн мэдээлэл


2018 оны жилийн эцсийн байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 550 979 /71.7%/ хүн хамрагдаж, 42.3 хувь нь эрэгтэй, 57.7 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр онош батлагдсан 2.0 хувь байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 520 446 /67.8%/ хүн хамрагдаж, 42.2 хувь нь эрэгтэй, 57.8 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр онош батлагдсан 0.2 хувь байна.

Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 233 840 хүн хамрагдсанаас 223 тохиолдолд хавдар оношлогдсон байна.

### 2.2. Жирэмсний хяналт

2018 оны жилийн эцсийн байдлаар жирэмсний хяналтад шинээр 78 199 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 88.1 хувь нь эхний 3 сартайд, 10.8 хувь нь 4-6 сартайд, 1.1 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтад орсон байна. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 97.9 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсанаас 3.4 хувь нь цус багадалттай байна. Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 91.8 хувь, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 91.4 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 97.7 хувь, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 97.0 хувь нь хамрагдсан байна.

**Зураг 8. Жирэмсний эрт хяналтын хувь, аймгаар /2018 оны жилийн эцсийн байдлаар/**



**Хүснэгт 2. БЗДХ-ын шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо /2018 оны жилийн эцсийн байдлаар/**

	Трихомониаз	Үүнээс эерэг	Заг хүйтэн	Үүнээс эерэг	Тэмбүү	Үүнээс эерэг
Архангай	1396	7	1380	0	1861	35
Баян-Өлгий	1681	9	1686	14	2299	15
Баянхонгор	1961	134	1961	25	2137	38
Булган	1080	33	1080	5	1077	9
Говь-Алтай	883	3	874	2	1242	23
Говьсүмбэр	362	5	362	0	362	10
Дархан-Уул	2446	60	2446	3	2446	22
Дорноговь	1630	27	1630	10	1630	21
Дорнод	1518	49	1621	23	1950	41
Дундговь	759	7	651	2	794	16
Завхан	1378	0	1375	1	1436	29
Орхон	2005	79	2005	0	2005	62
Өвөрхангай	2197	2	2197	3	2469	69
Өмнөговь	1526	27	1527	0	1975	10
Сүхбаатар	1362	40	1362	19	1362	22
Сэлэнгэ	2022	88	1950	9	2243	46
Төв	1290	40	1263	4	1669	17
Увс	1346	37	1376	9	1747	53
Ховд	2193	18	2178	6	2360	62
Хөвсгөл	2469	65	2470	74	2529	147
Хэнтий	1143	22	915	0	1646	27
<b>Аймгийн дүн</b>	<b>32647</b>	<b>752</b>	<b>32309</b>	<b>209</b>	<b>37239</b>	<b>774</b>
Улаанбаатар	39163	550	39163	87	39163	733
<b>Улсын дүн</b>	<b>71810</b>	<b>1302</b>	<b>71472</b>	<b>296</b>	<b>76402</b>	<b>1507</b>

**Хүснэгт 3. Түргэн тусламжийн дуудлага /2018 оны жилийн эцсийн байдлаар/**

	Түргэн тусламжийн дуудлага			Нийт дуудлаганд эзлэх хувь	Алсын дуудлагын эзлэх хувь	Осол, гэмтлийн дуудлагын эзлэх хувь
	Нийт	Алсын дуудлага	Осол, гэмтлийн дуудлага			
Архангай	18570	3870	607	2.4	20.8	3.3
Баян-Өлгий	26274	7875	238	3.4	30.0	0.9
Баянхонгор	17668	3571	850	2.3	20.2	4.8
Булган	15065	665	363	2.0	4.4	2.4
Говь-Алтай	15366	2587	459	2.0	16.8	3.0
Говьсүмбэр	6816	432	264	0.9	6.3	3.9
Дархан-Уул	20223	720	1083	2.6	3.6	5.4
Дорноговь	19741	3106	1008	2.6	15.7	5.1
Дорнод	14401	2248	737	1.9	15.6	5.1
Дундговь	14539	2513	422	1.9	17.3	2.9
Завхан	18087	3419	525	2.3	18.9	2.9
Орхон	15749	324	694	2.0	2.1	4.4
Өвөрхангай	18287	5559	685	2.4	30.4	3.7
Өмнөговь	11436	1607	489	1.5	14.1	4.3
Сүхбаатар	17488	4210	459	2.3	24.1	2.6
Сэлэнгэ	33645	4243	606	4.4	12.6	1.8
Төв	18405	4718	363	2.4	25.6	2.0
Увс	18700	4348	245	2.4	23.3	1.3
Ховд	17346	4218	272	2.2	24.3	1.6
Хөвсгөл	21005	3539	758	2.7	16.8	3.6
Хэнтий	23458	4114	466	3.0	17.5	2.0
<b>Аймгийн дүн</b>	<b>382269</b>	<b>67886</b>	<b>11593</b>	<b>49.6</b>	<b>17.8</b>	<b>3.0</b>
Улаанбаатар	389138	228	54846	50.4	0.1	14.1
<b>Улсын дүн</b>	<b>771407</b>	<b>68114</b>	<b>66439</b>	<b>100.0</b>	<b>8.8</b>	<b>8.6</b>

Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 771 407 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилсэнээс 8.8 хувийг алсын, 8.6 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байна.


**2.3. Хэвтэн эмчлүүлэгсдийн тусламж үйлчилгээ**

Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 902 439 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж, 6 438 504 ор хоног ашигласан байна. Улсын дунджаар орны фонд ашиглалтын хувь 81.6 дундаж ор хоног 7.1 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэвтэн эмчлүүлэгч 48 601 тохиолдлоор, ор хоног 295 935 тохиолдлоор тус тус өссөн байна.

### 3. Нас баралт

2018 оны жилийн эцсийн байдлаар нас баралтын 17 331 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1519 тохиолдлоор өссөн байна. Нийт нас баралтын 10 437 тохиолдол буюу 60.2 хувь нь эрэгтэй, 6894 буюу 39.8 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 27.2 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 1047 тохиолдол буюу 22.2 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Хоног болоогүй нас баралт нь өмнөх оны мөн үеэс 80 тохиолдлоор өссөн хэдий ч нас баралтын хувь нь 0.3-аар буурсан үзүүлэлттэй байна. Нас баралтын түвшин 1000 хүн амд 5.6 байна. Нас баралтын 6.0 хувийг нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 7.6 хувийг тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл эзэлж байна. Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 2918 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 16.8 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 292 тохиолдлоор өссөн бөгөөд 10 000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 9.4 байна.

Зураг 9. Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт, хувиар /2018 оны жилийн эцсийн байдлаар/



Хүснэгт 4. Аймаг, хотын нэгдсэн эмнэлгүүдэд хийгдсэн задлан шинжилгээ /2018 оны жилийн эцсийн байдлаар/

№	Аймаг нэр	Эдийн шинжилгээ	Эсийн шинжилгээ	Аймаг, хотын нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн нас баралт	Аймаг, хотын нэгдсэн эмнэлэгт хийгдсэн задлан шинжилгээ		Аймаг, хотын нэгдсэн эмнэлгийн амьгүй төрөлт	Амьгүй төрөлтөд хийгдсэн задлан шинжилгээ	Задлан шинжилгээ хийгээгүй	Задлан шинжилгээний хувь	Оношийн зөрүү	Оношийн зөрүүний хувь
					Эмгэг судлалын	Шүүх эмнэлгийн						
1	Архангай	850	4190	33	26	2	8	7	5	85.37%	6	18.2%
2	Баян-Өлгий	247	2116	72	6	0	16	2	67	9.09%	3	37.5%
3	Баянхонгор	640	5032	63	30	3	9	9	30	58.33%	0	0.0%
4	Булган	0	2190	18	11	0	2	2	7	65.00%	0	0.0%
5	Говь-Алтай	713	1867	28	16	0	7	7	12	65.71%	1	4.3%
6	Говьсүмбэр	0	767	4	3	0	1	1	1	80.00%	0	0.0%
7	Дархан-Уул	1417	4123	85	42	15	6	4	30	67.03%	2	4.3%
8	Дорноговь	1059	3717	44	43	1	5	5	0	100.00%	0	0.0%
9	Дорнод	1012	4576	90	44	9	9	9	37	62.63%	4	7.5%
10	Дундговь	0	1955	35	14	2	2	2	19	48.65%	2	12.5%
11	Завхан	138	1575	43	17	3	4	3	23	48.94%	1	5.0%
12	Орхон	1428	2804	101	55	7	11	11	39	65.18%	2	3.0%
13	Өвөрхангай	1053	5222	68	33	9	8	7	27	64.47%	2	5.0%
14	Өмнөговь	865	1478	43	25	6	1	1	12	72.73%	2	7.7%
15	Сүхбаатар	670	3133	37	24	4	5	5	9	78.57%	0	0.0%
16	Сэлэнгэ	189	3612	18	14	0	1	1	4	78.95%	0	0.0%
17	Төв	678	3622	34	20	0	1	1	14	60.00%	4	19.0%
18	Увс	1293	4484	36	30	4	7	6	3	93.02%	5	13.9%
19	Ховд	990	3848	54	28	4	15	12	23	63.77%	2	5.0%
20	Хөвсгөл	1725	6606	101	54	9	10	10	38	65.77%	6	9.4%
21	Хэнтий	324	3339	22	11	1	5	3	12	55.56%	2	14.3%
22	<b>Аймгийн дүн</b>	<b>15291</b>	<b>70256</b>	<b>1029</b>	<b>546</b>	<b>79</b>	<b>133</b>	<b>108</b>	<b>412</b>	<b>63.08%</b>	<b>44</b>	<b>6.7%</b>
23	Улаанбаатар	46681	21072	2689	1276	323	266	258	1101	62.84%	94	6.1%
24	<b>Улсын дүн</b>	<b>61972</b>	<b>91328</b>	<b>3718</b>	<b>1822</b>	<b>402</b>	<b>399</b>	<b>366</b>	<b>1513</b>	<b>62.91%</b>	<b>138</b>	<b>6.3%</b>

2018 оны жилийн эцсийн байдлаар аймаг хотын нэгдсэн эмнэлгүүдэд нас баралтын 3718 тохиолдол бүртгэгдсэнээс 62.9 хувьд нь эмгэг судлалын болон шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийгдсэн байна. Задлан шинжилгээний хувь Баян-Өлгий /9.1/, Завхан /48.9/, Дундговь /48.7/, Хэнтий /55.6/, Төв /60.0/, Дорнод /62.6/ байгаа нь аймгийн дундаж үзүүлэлтээс доогуур үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд үндсэн оношийн зөрүү 138 бүртгэгдэж, оношийн зөрүүний хувь 6.3 байна.



## 4. Халдварт өвчин

Улсын хэмжээнд 27 төрлийн 42 074 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 132.4 ногдож байна. Өмнөх оны мөн үеэс 2226 тохиолдлоор буюу 10 000 хүн амд ногдох өвчлөл 12.5-оор буурсан байна. 10 000 хүн амд ногдох халдварт өвчлөл Дорнод /354.5/, Хөвсгөл /184.4/, Баянхонгор /167.3/, Говьсүмбэр /150.7/ аймгууд болон Улаанбаатар хотод /164.4/ улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад цусан суулга /2239/, гонококкт халдвар /1039/, бактерийн гаралтай бусад хоолны хордлого /421/, мөөгөнцөртөх /268/, трихомониаз /241/, сальмонеллэз /144/, гахайн хавдар /100/, халдварын гаралтай гастроэнтерит ба суулга /87/, нярайн бактерт үжил /11/, татран /1/, денге чичрэг /1/ тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна.

**Зураг 10. Бүртгэгдсэн халдварт өвчний бүтэц, хувиар /2018 оны жилийн эцсийн байдлаар/**




### 4.1. Вирүст гепатит

Вирүст гепатит өвчний 475 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 1.5 ногдож байна. Нийт халдварт өвчний 1.1 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс 59 тохиолдлоор буурсан байна. Нийт вирүст гепатит өвчлөлийн 5.5 хувийг цочмог А гепатит, 56.6 хувийг цочмог В гепатит, 19.6 хувийг цочмог С гепатит тус тус эзэлж байна.

### 4.2. Амьсгалын замын халдварт өвчин

Амьсгалын замын цочмог халдварт өвчний 13 122 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 31.2 хувийг эзэлж байна. Амьсгалын замын халдвар өмнөх оноос 2683 тохиолдлоор буурсан байна.

**Зураг 11. Амьсгалын замын халдварт өвчин, бодит тоо /2014-2018 оны жилийн эцсийн байдлаар/**




### 4.3. Салхинцэцэг

Салхинцэцэг өвчний 8130 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 25.6 байна. Нийт халдварт өвчний 19.3 хувийг эзэлж өмнөх оны мөн үеэс 1513 тохиолдлоор буурсан байна. 10 000 хүн амд ногдох салхинцэцгийн өвчлөл Дорнод /73.5/, Өмнөговь /36.4/, Дархан-Уул /29.7/, Говь-Алтай /28.0/, Хөвсгөл /26.9/ аймгууд болон Улаанбаатар хотод /32.0/ улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна.

#### 4.4. Сүрьеэ

Сүрьеэ өвчний 3498 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 8.3 хувийг эзэлж байна. 10 000 хүн амд ногдох өвчлөл 11.0 байна. Өнгөрсөн оны мөн үеэс 281 тохиолдлоор буурсан байна. Нийт өвчлөлийн 2069 тохиолдол буюу 59.1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.


**Зураг 12. Сүрьеэгийн өвчлөл, 10 000 хүн амд /2018 оны жилийн эцсийн байдлаар/**



#### 4.5. Бэлгийн замаар дамжих халдвар

Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол 16 130 бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 38.3 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 766 өвчлөл буюу 5.0 хувиар өссөн байна. Нийт өвчлөлийн 33.9 хувийг заг хүйтэн, 38.2 хувийг тэмбүү, 27.8 хувийг трихомониазын халдвар, 0.1 хувийг ХДХВ/ДОХ тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тэмбүүгийн өвчлөл 507 тохиолдлоор буурсан ба 10 000 хүн амд ногдох өвчлөл Хөвсгөл /46.5/, Говьсүмбэр /33.4/, Сүхбаатар /32.1/, Баянхонгор /29.6/, Дорнод /29.0/, Говь-Алтай /28.5/, Хэнтий /22.2/, Сэлэнгэ /20.5/ аймгуудад улсын дундажаас өндөр байна.

**Зураг 13. Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдвар, / 2016-2018 оны жилийн эцсийн байдлаар/**



#### 5. Халдварт өвчний шалтгаант нас баралт

2018 оны жилийн эцсийн байдлаар халдварт өвчний шалтгаант нас баралтын нийт 111 тохиолдол бүртгэгдсэнээс сүрьеэ /88/, төрөлх тэмбүү /11/, нярайн бактерт үжил /3/, менингококкт халдвар /2/, вирүст хепатит /2/, цусан суулга /2/, хачигт рикеттсиоз /1/, ХДХВ/ДОХ /1/, хачигт энцефалит /1/ тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

**Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт 2017, 2018 оны жилийн эцсийн байдлаар**

Аймаг хот	Төрсөн эх			Амьд төрсөн хүүхэд					Амьгүй төрсөн хүүхэд	
	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	2017 онд	2018 онд
									2017 онд	2018 онд
1. Архангай	1890	1737	1957	1902	1738	1966	1966	6	10	
2. Баян-Өлгий	2844	2913	2831	2849	2919	2832	2832	25	22	
3. Баянхонгор	1997	2066	2064	2001	2074	2071	2071	10	12	
4. Булган	825	778	891	835	785	898	898	0	5	
5. Говь-Алтай	1216	1277	1221	1221	1286	1226	1226	7	9	
6. Говьсүмбэр	416	471	453	418	470	455	455	2	1	
7. Дархан-Уул	2249	2397	2519	2260	2408	2531	2531	8	6	
8. Дорноговь	1318	1365	1425	1325	1371	1434	1434	6	6	
9. Дорнод	1922	1948	1976	1934	1957	1984	1984	14	10	
10. Дундговь	878	904	936	881	912	939	939	3	3	
11. Завхан	1321	1431	1481	1329	1431	1485	1485	8	5	
12. Орхон	2566	2731	2680	2579	2751	2696	2696	17	11	
13. Өвөрхангай	2417	2404	2594	2428	2403	2604	2604	10	13	
14. Өмнөговь	1297	1536	1436	1301	1552	1441	1441	11	1	
15. Сүхбаатар	1275	1300	1310	1275	1307	1314	1314	7	6	
16. Сэлэнгэ	1712	1705	1842	1720	1706	1849	1849	6	4	
17. Төв	1192	1141	1232	1197	1147	1234	1234	4	3	
18. Увс	2029	1896	2012	2036	1912	2025	2025	14	7	
19. Ховд	2196	2349	2304	2212	2355	2277	2277	16	17	
20. Хөвсгөл	2767	2880	3007	2775	2881	3013	3013	15	15	
21. Хэнтий	1442	1456	1559	1446	1460	1562	1562	8	8	
<b>Аймгийн дүн</b>	<b>35769</b>	<b>36685</b>	<b>37731</b>	<b>35924</b>	<b>36825</b>	<b>37834</b>	<b>37834</b>	<b>197</b>	<b>174</b>	
22. Улаанбаатар	38115	40373	40357	38404	40703	40662	40662	254	264	
<b>Улсын дүн</b>	<b>73884</b>	<b>77058</b>	<b>78088</b>	<b>74328</b>	<b>77528</b>	<b>78497</b>	<b>78497</b>	<b>451</b>	<b>438</b>	

**Эхийн эндэгдэл, 2017, 2018 оны жилийн эцсийн байдлаар**

Аймаг хот	Нас барсан эх		Эхийн эндэгдэл /100 000 хүн амд/				
	2017 онд	2018 онд	2017 онд	2018 онд	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж
1. Архангай	0	2	0.0	0.0	115.1	50.9	
2. Баян-Өлгий	1	0	35.1	0.0	0.0	35.3	
3. Баянхонгор	0	0	0.0	0.0	0.0	67.6	
4. Булган	0	0	0.0	0.0	0.0	0.0	
5. Говь-Алтай	0	0	0.0	0.0	0.0	0.0	
6. Говьсүмбэр	0	0	0.0	0.0	0.0	0.0	
7. Дархан-Уул	0	2	0.0	83.1	23.7	23.7	
8. Дорноговь	0	0	0.0	0.0	0.0	0.0	
9. Дорнод	0	0	0.0	0.0	0.0	0.0	
10. Дундговь	0	0	0.0	0.0	0.0	0.0	
11. Завхан	2	0	150.5	0.0	0.0	26.9	
12. Орхон	0	0	0.0	0.0	0.0	7.4	
13. Өвөрхангай	0	0	0.0	0.0	0.0	23.0	
14. Өмнөговь	1	0	76.9	0.0	0.0	83.3	
15. Сүхбаатар	1	0	78.4	0.0	0.0	45.7	
16. Сэлэнгэ	0	1	0.0	58.6	43.3	43.3	
17. Төв	0	0	0.0	0.0	0.0	32.4	
18. Увс	1	0	49.1	0.0	0.0	9.9	
19. Ховд	1	3	45.2	127.4	87.8	39.8	
20. Хөвсгөл	0	1	0.0	34.7	25.6	25.6	
21. Хэнтий	1	0	69.2	0.0	0.0	31.7	
<b>Аймгийн дүн</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>22.3</b>	<b>24.4</b>	<b>24.4</b>	<b>31.7</b>	
22. Улаанбаатар	12	12	31.2	29.5	33.4	33.4	
<b>Улсын дүн</b>	<b>20</b>	<b>21</b>	<b>26.9</b>	<b>27.1</b>	<b>27.1</b>	<b>32.6</b>	

**Төрсөн хүүхдийн мэдээ, 2018 оны жилийн эцсийн байдлаар**

Аймаг хот	Амьд төрсөн хүүхэд				1000 нийт төрөлтөд	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	1 цайин дотор хөхөө амласан хүүхдийн хувь		Бага жинтэй хүүхдийн хувь
1. Архангай	1738	872	866	90.1	3.9	5.7
2. Баян-Өлгий	2919	1506	1413	99.6	4.8	7.5
3. Баянхонгор	2074	1037	1037	99.7	4.7	5.8
4. Булган	785	425	360	94.5	3.1	6.3
5. Говь-Алтай	1286	678	608	97.0	5.1	6.9
6. Говьсүмбэр	470	230	240	98.7	1.1	2.1
7. Дархан-Уул	2408	1281	1127	91.9	3.4	2.5
8. Дорноговь	1371	718	653	98.9	2.2	4.4
9. Дорнод	1957	965	992	98.8	3.0	5.1
10. Дундговь	912	494	418	99.0	3.1	3.3
11. Завхан	1431	724	707	98.0	4.0	3.5
12. Орхон	2751	1452	1299	98.2	3.8	4.0
13. Өвөрхангай	2403	1255	1148	92.5	3.4	5.4
14. Өмнөговь	1552	775	777	98.3	4.7	0.6
15. Сүхбаатар	1307	679	628	95.1	3.5	4.6
16. Сэлэнгэ	1706	876	830	96.5	2.2	2.3
17. Төв	1147	611	536	96.3	3.9	2.6
18. Увс	1912	959	953	94.6	3.8	3.6
19. Ховд	2355	1198	1157	99.8	4.0	7.2
20. Хөвсгөл	2881	1498	1383	95.3	3.7	5.2
21. Хэнтий	1460	719	741	99.2	3.0	5.4
<b>Аймгийн дүн</b>	<b>36825</b>	<b>18952</b>	<b>17873</b>	<b>96.7</b>	<b>3.7</b>	<b>4.7</b>
22. Улаанбаатар	40703	20835	19868	96.2	5.1	6.4
<b>Улсын дүн</b>	<b>77528</b>	<b>39787</b>	<b>37741</b>	<b>96.4</b>	<b>4.4</b>	<b>5.6</b>

**Хүүхдийн эндэгдэл, 2017, 2018 оны жилийн эцсийн байдлаар**

Аймаг хот	Нялхсын эндэгдэл		Нялхсын эндэгдэл /1000 амьд төрөлтөд/				5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл				5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/			
	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	Нялхсын эндэгдэл /1000 амьд төрөлтөд/		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		
				2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	2017 онд	2018 онд	2017 онд	2018 онд	2017 онд	2018 онд
1. Архангай	32	34	32	16.8	19.6	16.1	39	44	43	20.5	25.3	21.8		
2. Баян-Өлгий	38	52	61	13.3	17.8	20.7	51	73	75	17.9	25.0	26.6		
3. Баянхонгор	31	24	33	15.5	11.6	17.3	36	39	43	18.0	18.8	20.9		
4. Булган	9	13	14	10.8	16.6	14.9	11	18	17	13.2	22.9	19.2		
5. Говь-Алтай	20	21	20	16.4	16.3	18.3	24	25	25	19.7	19.4	20.7		
6. Говьсүмбэр	3	1	4	7.2	2.1	11.9	6	3	6	14.4	6.4	12.3		
7. Дархан-Уул	24	26	25	10.6	10.8	9.8	29	33	31	12.8	13.7	12.3		
8. Дорноговь	17	16	19	12.8	11.7	13.1	18	22	22	13.6	16.0	15.6		
9. Дорнод	26	8	18	13.4	4.1	10.5	35	13	25	18.1	6.6	12.7		
10. Дундговь	8	7	11	9.1	7.7	12.0	14	12	15	15.9	13.2	16.0		
11. Завхан	22	19	29	16.6	13.3	20.3	23	29	34	17.3	20.3	22.6		
12. Орхон	13	18	28	5.0	6.5	11.0	14	26	33	5.4	9.5	12.2		
13. Өвөрхангай	39	36	41	16.1	15.0	15.5	49	46	53	20.2	19.1	20.5		
14. Өмнөговь	21	23	25	16.1	14.8	17.3	26	25	31	20.0	16.1	21.2		
15. Сүхбаатар	22	14	23	17.3	10.7	19.1	26	21	29	20.4	16.1	22.4		
16. Сэлэнгэ	19	18	19	11.0	10.6	8.9	26	21	25	15.1	12.3	13.3		
17. Төв	12	21	19	10.0	18.3	13.9	21	30	27	17.5	26.2	21.6		
18. Увс	38	27	38	18.7	14.1	19.2	45	38	47	22.1	19.9	23.1		
19. Ховд	37	35	40	16.7	14.9	17.6	49	45	51	22.2	19.1	22.5		
20. Хөвсгөл	61	52	64	22.0	18.0	22.2	73	68	77	26.3	23.6	25.7		
21. Хэнтий	28	17	24	19.4	11.6	16.1	36	22	31	24.9	15.1	20.0		
<b>Аймгийн дүн</b>	<b>520</b>	<b>482</b>	<b>587</b>	<b>14.5</b>	<b>13.1</b>	<b>15.8</b>	<b>651</b>	<b>651</b>	<b>741</b>	<b>18.1</b>	<b>17.7</b>	<b>19.6</b>		
22. Улаанбаатар	489	555	579	12.7	13.6	13.9	593	657	692	15.4	16.1	17.0		
<b>Улсын дүн</b>	<b>1009</b>	<b>1037</b>	<b>1166</b>	<b>13.6</b>	<b>13.4</b>	<b>14.8</b>	<b>1244</b>	<b>1310</b>	<b>1433</b>	<b>16.7</b>	<b>16.9</b>	<b>18.3</b>		

### Хүүхдийн эндэгдэл хүйсээр, 2018 оны жилийн эцсийн байдлаар

Аймаг хот	Нялхсын эндэгдэл			5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
1. Архангай	34	22	12	44	25	19
2. Баян-Өлгий	52	30	22	73	37	36
3. Баянхонгор	24	17	7	39	28	11
4. Булган	13	7	6	18	10	8
5. Говь-Алтай	21	13	8	25	15	10
6. Говьсүмбэр	1	1	0	3	1	2
7. Дархан-Уул	26	17	9	33	23	10
8. Дорноговь	16	10	6	22	13	9
9. Дорнод	8	5	3	13	7	6
10. Дундговь	7	6	1	12	8	4
11. Завхан	19	10	9	29	15	14
12. Орхон	18	11	7	26	16	10
13. Өвөрхангай	36	23	13	46	31	15
14. Өмнөговь	23	12	11	25	13	12
15. Сүхбаатар	14	9	5	21	14	7
16. Сэлэнгэ	18	14	4	21	16	5
17. Төв	21	7	14	30	12	18
18. Увс	27	18	9	38	23	15
19. Ховд	35	18	17	45	20	25
20. Хөвсгөл	52	27	25	68	39	29
21. Хэнтий	17	9	8	22	14	8
<b>АЙМГИЙН ДҮН</b>	<b>482</b>	<b>286</b>	<b>196</b>	<b>653</b>	<b>380</b>	<b>273</b>
22. Улаанбаатар	555	316	239	657	377	280
<b>Улсын дүн</b>	<b>1037</b>	<b>602</b>	<b>435</b>	<b>1310</b>	<b>757</b>	<b>553</b>

### Нас баралт, 2017, 2018 оны жилийн эцсийн байдлаар

Аймаг хот	Бүх нас баралт			Үүнээс: эмнэлэгт			Эмнэлэгт хоног болоогүй		
	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж
	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж
1. Архангай	449	516	480	71	102	101	20	25	24
2. Баян-Өлгий	448	502	494	79	100	114	27	35	33
3. Баянхонгор	443	505	484	106	107	121	32	27	35
4. Булган	338	326	330	55	44	55	12	10	16
5. Говь-Алтай	292	311	283	79	73	79	14	11	14
6. Говьсүмбэр	91	64	78	9	9	12	7	3	6
7. Дархан-Уул	545	572	559	91	87	95	43	32	40
8. Дорноговь	340	402	364	55	75	68	29	23	25
9. Дорнод	430	436	458	110	111	113	35	33	31
10. Дундговь	231	264	249	38	45	38	15	21	18
11. Завхан	369	369	382	76	82	86	19	20	20
12. Орхон	493	520	518	82	103	87	29	40	33
13. Өвөрхангай	601	660	629	144	139	140	37	45	40
14. Өмнөговь	307	323	317	90	88	83	30	35	30
15. Сүхбаатар	316	356	337	61	64	59	19	19	18
16. Сэлэнгэ	494	529	521	31	37	39	8	8	9
17. Төв	420	470	431	66	70	66	15	21	23
18. Увс	430	457	445	68	66	72	22	15	21
19. Ховд	425	415	398	95	79	92	18	21	16
20. Хөвсгөл	792	793	800	141	158	154	38	49	45
21. Хэнтий	351	361	557	74	59	70	35	20	23
<b>АЙМГИЙН ДҮН</b>	<b>8605</b>	<b>9151</b>	<b>9114</b>	<b>1621</b>	<b>1698</b>	<b>1742</b>	<b>504</b>	<b>513</b>	<b>522</b>
22. Улаанбаатар	7207	8180	7491	2671	3023	2710	463	534	501
<b>Улсын дүн</b>	<b>15812</b>	<b>17331</b>	<b>16605</b>	<b>4292</b>	<b>4721</b>	<b>4452</b>	<b>967</b>	<b>1047</b>	<b>1023</b>

**Амбулатор, стационарын тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлтүүд  
2018 оны жилийн эцсийн байдлаар**

Аймаг хот	Бүгд үзлэг	Үүнээс					Сумчиглэсэн хонин	Дундаж орон	Бүртгэгдсэн өвчлөл			
		Урьдчилан сэргийлэх үзлэг	Өвчний учир амбулаторит	Идэвхтэй хяналт	Гэрийн идэвхтэй	Гэрийн дуудлаг-аар			2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	
1. Архангай	308333	115474	136361	27532	20511	8455	20800	144751	7.0	75350	71087	63051
2. Баян-Өлгий	348197	99424	151148	29851	48365	19409	27132	190015	7.0	26639	34574	23617
3. Баянхонгор	278018	78230	107123	40206	48994	5465	20900	144693	6.9	70422	83040	65608
4. Булган	182064	57202	92873	18306	10235	3448	12557	87860	7.0	53446	43488	40233
5. Говь-Алтай	231977	55200	126337	17577	25463	7400	14262	104827	7.4	27313	32618	24036
6. Говьсүмбэр	109970	30482	61438	11045	6814	191	5143	37111	7.2	5795	6406	5738
7. Дархан-Уул	609829	227817	220070	46888	112651	2403	31111	222557	7.2	59239	58176	55708
8. Дорноговь	353716	117137	159977	48747	25288	6567	16900	120618	7.1	76238	76335	52703
9. Дорнод	387175	157377	141709	42266	40636	5187	19159	142981	7.5	39675	40333	37763
10. Дундговь	177034	55573	79461	28688	9436	3876	11119	80105	7.2	15697	22975	16463
11. Завхан	311967	97034	149203	17822	33523	14385	17213	130083	7.6	45604	49805	33324
12. Орхон	596566	230317	220445	59317	83280	3207	25114	179386	7.1	37028	25949	33043
13. Өвөрхангай	371583	99544	177119	44367	40967	9586	24559	175015	7.1	64235	59626	56107
14. Өмнөговь	319272	113272	142319	46855	13037	3789	15068	98399	6.5	56600	64377	51995
15. Сүхбаатар	233408	74097	104780	40030	9552	4949	13555	109340	8.1	30946	31728	29139
16. Сэлэнгэ	389660	124329	182333	54187	26187	2624	23241	177180	7.6	30901	33637	29399
17. Төв	280879	152930	99639	15218	9146	3946	15546	116888	7.5	68263	84105	66089
18. Увс	381437	108935	187463	36010	37728	12401	21020	134841	6.4	45554	53087	42553
19. Ховд	350923	93079	147739	57018	45791	7296	23743	172822	7.3	39631	58413	51807
20. Хөвсгөл	418082	130359	205562	45761	26750	9650	29764	197498	6.6	75014	74011	57605
21. Хэнтий	328478	104754	145667	44588	23684	9785	16592	123686	7.5	38310	41883	33771
<b>Аймгийн дүн</b>	<b>6968568</b>	<b>2320466</b>	<b>3034766</b>	<b>771279</b>	<b>698038</b>	<b>144019</b>	<b>404498</b>	<b>2890656</b>	<b>7.1</b>	<b>981900</b>	<b>1045653</b>	<b>849753</b>
22. Улаанбаатар	10484182	2994847	5543605	773962	1137330	34438	497941	3547848	7.1	992657	1038888	882444
<b>Улсын дүн</b>	<b>17452750</b>	<b>5315313</b>	<b>8578371</b>	<b>1545241</b>	<b>1835368</b>	<b>178457</b>	<b>902439</b>	<b>6438504</b>	<b>7.1</b>	<b>1974557</b>	<b>2084521</b>	<b>1732197</b>

**Халдварт өвчин, 2017, 2018 оны жилийн эцсийн байдлаар**

Аймаг хот	Бүртгэгдсэн бүх халдварт өвчлөл						
	Өвчлөл		10 000 хүн амд				
	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	Тас гаргалт
1. Архангай	491	582	731	53.3	61.2	78.5	5
2. Баян-Өлгий	332	313	451	33.1	30.5	45.2	0
3. Баянхонгор	1127	1448	1453	134.3	167.2	172.0	3
4. Булган	480	347	475	80.0	56.6	78.5	0
5. Говь-Алтай	787	482	447	140.0	83.8	78.9	0
6. Говьсүмбэр	234	262	212	141.6	150.7	127.0	1
7. Дархан-Уул	939	1188	1415	93.0	114.2	139.4	0
8. Дорноговь	687	737	978	105.3	108.1	148.7	3
9. Дорнод	2915	2816	2626	381.2	354.5	340.8	6
10. Дундговь	491	407	478	110.5	89.0	106.7	1
11. Завхан	457	455	527	65.4	63.6	75.0	0
12. Орхон	673	883	841	66.8	84.9	83.8	5
13. Өвөрхангай	1114	1013	1148	99.2	88.0	101.4	2
14. Өмнөговь	714	632	760	115.8	96.8	122.0	0
15. Сүхбаатар	1276	678	915	216.1	110.9	154.3	3
16. Сэлэнгэ	775	806	1007	72.9	73.5	94.0	0
17. Төв	804	662	883	88.9	70.4	96.7	5
18. Увс	711	614	674	88.0	74.3	83.9	4
19. Ховд	516	629	728	61.8	72.8	86.8	0
20. Хөвсгөл	1532	2426	1890	119.5	184.4	146.9	1
21. Хэнтий	690	638	834	95.0	84.3	114.0	1
<b>Аймгийн дүн</b>	<b>17745</b>	<b>18018</b>	<b>19472</b>	<b>106.8</b>	<b>105.1</b>	<b>116.6</b>	<b>40</b>
22. Улаанбаатар	26555	24056	30023	190.2	164.4	212.7	71
<b>Улсын дүн</b>	<b>44300</b>	<b>42074</b>	<b>49495</b>	<b>144.9</b>	<b>132.4</b>	<b>160.6</b>	<b>111</b>

**Бүртгэгдсэн бүх халдварт өвчлөл, 2017, 2018 оны жилийн эцсийн байдлаар**

№	Халдварт өвчин /ӨОУА 10 нэршлээр/	Өвчлөл			10 000 хүн амд			Цэвэрлэгч
		2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	
		0	0	0	0	0.0	0.0	
1	Холер (A00)	0	0	0	0.0	0.0	0.0	0
2	Балнад( A01)	0	0	1	0.0	0.0	0.0	0
3	Сальмонеллэз ( A02)	185	329	187	0.6	1.0	0.6	0
4	Цусан суулга ( A03)	4026	6265	3634	13.2	19.7	11.8	2
5	Хүннээс гаралтай бактерт хордлого ( A05)	133	554	429	0.4	1.7	1.4	0
6	Суулгалт халдвар ( A09)	103	190	95	0.3	0.6	0.3	0
7	Сүрьеэ (A15-A19)	3779	3498	3915	12.4	11.0	12.7	88
8	Тарваган тахал (A20)	1	0	1	0.0	0.0	0.0	0
9	Хүний боом өвчин (A22)	1	0	4	0.0	0.0	0.0	0
10	Бруцеллэз ( A23)	144	107	193	0.5	0.3	0.6	0
11	Татран (A33-A35)	0	1	0	0.0	0.0	0.0	0
12	Сахуу (A 36)	0	0	0	0.0	0.0	0.0	0
13	Хөхүүл ханиад (A37)	0	0	0	0.0	0.0	0.0	0
14	Улаан эсэргэнэ (A38)	1797	922	1025	5.9	2.9	3.3	0
15	Менингококкт халдвар ( A39)	13	12	12	0.0	0.0	0.0	2
16	Ёлом (A46)	236	188	172	0.8	0.6	0.6	0
17	Хийт үлжил (A48)	0	0	0	0.0	0.0	0.0	0
18	Тэмбүү (A50-A53)	6670	6163	6571	21.8	19.4	21.3	11
	Үүнээс: төрөлхийн тэмбүү /A50/	59	49	44	0.2	0.2	0.1	11
19	Гонкоккт халдвар (A54)	4422	5461	4884	14.5	17.2	15.2	0
20	Трихомониаз (A59)	4247	4488	4133	13.9	14.1	13.4	0
21	Хачигт боррелиоз (A69)	46	24	33	0.2	0.1	0.1	0

№	Халдварт өвчин /ӨОУА 10 нэршлээр/	Өвчлөл			10 000 хүн амд			Цэвэрлэгч
		2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	
		357	203	228	1.2	0.6	0.7	
22	Хачигт рикеттсиоз (A77)	357	203	228	1.2	0.6	0.7	1
23	Цочмог полиомиелит (A80)	0	0	0	0.0	0.0	0.0	0
24	Галзуу (A82)	0	0	0	0.0	0.0	0.0	0
25	Хачигт энцефалит (A84)	62	32	40	0.2	0.1	0.1	1
26	Денге чинрэг (A90)	0	1	0	0.0	0.0	0.0	0
27	Салхинцэцэг (B01)	9643	8130	6896	31.5	25.6	22.4	0
28	Улаанбурхан (B05)	17	1	10652	0.1	0.0	34.6	0
29	Улаанууд (B06)	11	4	23	0.0	0.0	0.1	0
30	Халдварт эритема (B08.3)	90	48	61	0.3	0.2	0.2	0
31	Гар, хөл, амны өвчин ( B08.4)	6051	2876	3554	19.8	9.1	11.5	0
32	Вируст гепатит ( B15-B19)	534	475	706	1.7	1.5	2.3	2
	Вируст гепатит (A)	51	26	100	0.2	0.1	0.3	-
	Вируст гепатит (B)	304	269	388	1.0	0.8	1.3	-
	Вируст гепатит (C)	91	93	108	0.3	0.3	0.4	-
33	ХДХВ / ДОХ (B20-B24)	25	18	24	0.1	0.1	0.1	1
34	Гахай хавдар (B26)	219	319	307	0.7	1.0	1.0	0
35	Мөөгөнцөртех ( B35-B49)	1480	1748	1705	4.8	5.5	5.5	0
36	Нярайн бактерт үжил (P36)	6	17	10	0.0	0.1	0.0	3
37	AЦХАХ/ISARS (B34.2)	0	0	0	0.0	0.0	0.0	0
38	Хумхаа (B50)	2	0	1	0.0	0.0	0.0	0
39	<b>БҮГД</b>	<b>44300</b>	<b>42074</b>	<b>49495</b>	<b>144.9</b>	<b>132.4</b>	<b>160.6</b>	<b>111</b>

## 1. Гэдэсний халдварт өвчин

Аймаг хот	A00 Холер /Cholera/						A01 Баллад /Typhoid and paratyphoid fevers/					
	Өвчлөл			10 000 хүн амд			Өвчлөл			10 000 хүн амд		
	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж
1. Архангай	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
2. Баян-Өлгий	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
3. Баянхонгор	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
4. Булган	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
5. Говь-Алтай	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
6. Говьсүмбэр	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
7. Дархан-Уул	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
8. Дорноговь	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
9. Дорнод	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
10. Дундговь	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
11. Завхан	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
12. Орхон	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
13. Өвөрхангай	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
14. Өмнөговь	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
15. Сүхбаатар	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
16. Сэлэнгэ	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
17. Төв	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
18. Увс	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
19. Ховд	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
20. Хөвсгөл	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
21. Хэнтий	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
<b>Аймгийн дүн</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
22. Улаанбаатар	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0.0	0.0	0.0
<b>Улсын дүн</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>

Аймаг хот	A02 Сальмонеллез /Other salmonella infections/						A03 Цусан суулга /Shigellosis/						
	Өвчлөл			10 000 хүн амд			Өвчлөл			10 000 хүн амд			
	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2016 онд	2017 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	
1. Архангай	0	4	2	0.0	0.4	0.2	0	51	74	43	5.5	7.8	4.6
2. Баян-Өлгий	0	0	0	0.0	0.0	0.0	0	3	3	5	0.3	0.3	0.5
3. Баянхонгор	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	14	3	0.0	1.6	0.4
4. Булган	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	22	5	0.0	3.6	0.8
5. Говь-Алтай	0	0	0	0.0	0.0	0.0	0	1	1	1	0.2	0.2	0.2
6. Говьсүмбэр	0	0	0	0.0	0.0	0.0	0	4	7	4	2.4	4.0	2.5
7. Дархан-Уул	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	10	2	0.0	1.0	0.2
8. Дорноговь	0	0	0	0.0	0.0	0.0	0	39	55	41	6.0	8.1	6.3
9. Дорнод	6	6	5	0.8	0.8	0.7	0	32	76	27	4.2	9.6	3.5
10. Дундговь	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	4	2	0.0	0.9	0.4
11. Завхан	0	0	0	0.0	0.0	0.0	0	7	22	12	1.0	3.1	1.7
12. Орхон	0	0	1	0.0	0.0	0.1	0	41	147	44	4.1	14.1	4.4
13. Өвөрхангай	5	2	2	0.4	0.2	0.2	0	135	209	89	12.0	18.2	7.8
14. Өмнөговь	0	2	1	0.0	0.3	0.1	0	48	23	65	7.8	3.5	10.5
15. Сүхбаатар	3	0	3	0.5	0.0	0.4	0	36	52	34	6.1	8.5	5.7
16. Сэлэнгэ	0	0	0	0.0	0.0	0.0	0	41	49	27	3.9	4.5	2.5
17. Төв	3	12	6	0.3	1.3	0.6	0	28	40	20	3.1	4.3	2.2
18. Увс	1	0	0	0.1	0.0	0.0	0	35	45	35	4.3	5.4	4.4
19. Ховд	1	0	1	0.1	0.0	0.1	0	3	18	5	0.4	2.1	0.6
20. Хөвсгөл	5	7	6	0.4	0.5	0.5	0	100	130	64	7.8	9.9	5.0
21. Хэнтий	0	0	0	0.0	0.0	0.1	0	24	50	42	3.3	6.6	5.8
<b>Аймгийн дүн</b>	<b>24</b>	<b>33</b>	<b>27</b>	<b>0.1</b>	<b>0.2</b>	<b>0.2</b>	<b>0</b>	<b>628</b>	<b>1051</b>	<b>571</b>	<b>3.8</b>	<b>6.1</b>	<b>3.4</b>
22. Улаанбаатар	161	296	160	1.2	2.0	1.1	0	3398	5214	3063	24.3	35.6	21.7
<b>Улсын дүн</b>	<b>185</b>	<b>329</b>	<b>187</b>	<b>0.6</b>	<b>1.0</b>	<b>0.6</b>	<b>0</b>	<b>4026</b>	<b>6265</b>	<b>3634</b>	<b>13.2</b>	<b>19.7</b>	<b>11.8</b>



Аймаг хот	A05 Бактерийн гаралтай бусад хоолны хордлого /Other bacterial foodborne intoxications/						A09 Халдварын гаралтай гастронтерит ба суулга /Diarrhoea and gastroenteritis of presumed infectious origin/						
	Өвчлөл			10 000 хүн амд			Өвчлөл			10 000 хүн амд			
	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	
1. Архангай	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0	0.0	0.0	0
2. Баян-Өлгий	8	73	34	0.8	7.1	3.4	0	0	0	0	0.0	0.0	0.0
3. Баянхонгор	7	0	1	0.8	0.0	0.2	0	29	26	18	3.5	3.0	2.2
4. Булган	0	0	0	0.0	0.0	0.0	0	2	13	3	0.3	2.1	0.5
5. Говь-Алтай	0	0	0	0.0	0.0	0.0	0	16	0	12	2.8	0.0	2.2
6. Говьсүмбэр	0	30	8	0.0	17.3	4.9	0	0	0	0	0.0	0.0	0.0
7. Дархан-Уул	17	0	45	1.7	0.0	4.5	0	4	0	2	0.4	0.0	0.2
8. Дорноговь	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	7	0.0	0.0	1.1
9. Дорнод	0	11	2	0.0	1.4	0.3	0	0	0	0	0.0	0.0	0.0
10. Дундговь	0	1	6	0.0	0.2	1.4	0	0	0	0	0.0	0.0	0.0
11. Завхан	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0	0.0	0.0	0.0
12. Орхон	3	36	24	0.3	3.5	2.4	0	49	133	47	4.9	12.8	4.6
13. Өвөрхангай	0	33	7	0.0	2.9	0.6	0	0	0	0	0.0	0.0	0.0
14. Өмнөговь	6	12	4	1.0	1.8	0.6	0	0	0	0	0.0	0.0	0.0
15. Сүхбаатар	0	0	1	0.0	0.0	0.1	0	0	0	0	0.0	0.0	0.0
16. Сэлэнгэ	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0	0.0	0.0	0.0
17. Төв	0	15	8	0.0	1.6	0.8	0	0	0	0	0.0	0.0	0.0
18. Увс	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	1	0.0	0.0	0.2
19. Ховд	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	0	0.0	0.0	0.0
20. Хөвсгөл	3	15	6	0.2	1.1	0.5	0	0	18	4	0.0	1.4	0.3
21. Хэнтий	0	0	0	0.0	0.0	0.0	0	3	0	1	0.4	0.0	0.1
<b>Аймгийн дүн</b>	<b>44</b>	<b>226</b>	<b>147</b>	<b>0.3</b>	<b>1.3</b>	<b>0.9</b>	<b>0</b>	<b>103</b>	<b>190</b>	<b>95</b>	<b>0.6</b>	<b>1.1</b>	<b>0.6</b>
22. Улаанбаатар	89	328	283	0.6	2.2	2.0	0	0	0	0	0.0	0.0	0.0
<b>Улсын дүн</b>	<b>133</b>	<b>554</b>	<b>429</b>	<b>0.4</b>	<b>1.7</b>	<b>1.4</b>	<b>0</b>	<b>103</b>	<b>190</b>	<b>95</b>	<b>0.3</b>	<b>0.6</b>	<b>0.3</b>

Аймаг хот	A80 Цочмог полиомелит /Acute poliomyelitis/						B08.4 Гар, хөл, амны өвчин /Hand, foot and mouth disease/						
	Өвчлөл			10 000 хүн амд			Өвчлөл			10 000 хүн амд			
	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	2017 онд	2018 онд	5 жилийн дундаж	
1. Архангай	0	0	0	0.0	0.0	0.0	0	20	11	12	2.2	1.2	1.3
2. Баян-Өлгий	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0	1	0.0	0.0	0.1
3. Баянхонгор	0	0	0	0.0	0.0	0.0	0	15	74	38	1.8	8.5	4.5
4. Булган	0	0	0	0.0	0.0	0.0	0	22	28	20	3.7	4.6	3.4
5. Говь-Алтай	0	0	0	0.0	0.0	0.0	0	162	36	41	28.8	6.3	7.2
6. Говьсүмбэр	0	0	0	0.0	0.0	0.0	0	16	26	11	9.7	15.0	6.7
7. Дархан-Уул	0	0	0	0.0	0.0	0.0	0	90	315	99	8.9	30.3	9.7
8. Дорноговь	0	0	0	0.0	0.0	0.0	0	87	16	29	13.3	2.3	4.4
9. Дорнод	0	0	0	0.0	0.0	0.0	0	392	209	178	51.3	26.3	23.1
10. Дундговь	0	0	0	0.0	0.0	0.0	0	105	84	57	23.6	18.4	12.6
11. Завхан	0	0	0	0.0	0.0	0.0	0	5	5	6	0.7	0.7	0.9
12. Орхон	0	0	0	0.0	0.0	0.0	0	19	27	24	1.9	2.6	2.4
13. Өвөрхангай	0	0	0	0.0	0.0	0.0	0	48	120	45	4.3	10.4	4.0
14. Өмнөговь	0	0	0	0.0	0.0	0.0	0	183	66	63	29.7	10.1	10.2
15. Сүхбаатар	0	0	0	0.0	0.0	0.0	0	280	36	83	47.4	5.9	14.1
16. Сэлэнгэ	0	0	0	0.0	0.0	0.0	0	4	4	3	0.4	0.4	0.2
17. Төв	0	0	0	0.0	0.0	0.0	0	122	94	89	13.5	10.0	9.8
